

СҮХБААТАР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар A/05

Баруун-Урт сум

Сүхбаатар аймагт эрүүл мэндийн байгууллага
үүсэж хөгжсөний 80 жилийн ойг
угтан зохион байгуулах төлөвлөгөө батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дах заалт, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар аймагт эрүүл мэндийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 80 жилийн ойг угтсан арга хэмжээний бүтээлч ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (О.Баярбаатар), Нийгмийн эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Азжаргал) нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч мэдээллийн (Н.Нямгэрэл)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  П.БОЛОРМАА

Эрүүл мэндийн газрын даргын
оны 01... –р сарын 26-өдрийн
А/ОС... –р тушаалын хавсралт

“Эрүүл мэндийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойг угтаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө”

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах хэлтэс	Хамтрагч байгууллага, албан тушаалтан
1	2	3	4	5
1	Төлөвлөгөөг батлуулах	2022-01-26	УТСХ	ЭТҮХ, ХШҮМХ, НЭМТ
2	“Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд “Эрэгтэйчүүдийн төлөө хамтдаа” аян зохион байгуулах	1-р улирал	НЭМТ	УТСХ, ЭТҮХ, ХШҮМХ
3	Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны манлайллыг нэмэгдүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн” зохион байгуулж сумдын засаг дарга, эрүүл мэндийн байгууллагуудын дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулах	1-р улирал	УТСХ	ЭМБ-ууд
4	Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгмийн баталгааг хангах, идэвх санаачилгыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн засаг даргын нэрэмжит шагналыг бий болгох, удирдамж боловсруулах, гардуулах	1-р улирал	УТСХ	АЗДТГ
5	“Шилдэг судлаач эмч, сувилагч тусгай мэргэжилтэн” -2022 эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах	1, 2 –р улирал	НЭМТ	ЭТҮХ, ЭМБ-ууд
6	Сум, Өрх –ийн ЭМТ, хувийн хэвшлийн НЭМ-ийн ажилчдыг оролцуулсан туршлага судлах ажлыг зохион байгуулах /Асгат сум/	2022-03-26	НЭМТ	ЭМБ-ууд
7	Өрх, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ” сургалт, зохион байгуулах	04 сарын 18-20	НЭМТ	ЭТҮХ

1	2	3	4	5
1	“Анхан шатны ЭМБ-н эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байрны сургалтад хамруулах	1-4 улирал	ЭТҮХ	АНЭ
8	Эмнэл зүйн олон улсын удирдамж “Up to Date” платформыг ашиглалтыг нэмэгдүүлэх, эмч нарт сургалтад хамруулах	2, 4-р улирал	ХШҮМХ	ЭТҮХ
9	Магадлан итгэмжлэлийн цахим программын ашиглалтыг сайжруулах, ЭМБ-уудыг арга зүйгээр хангаж, материалыг илгээх	1-4-р улирал	ЭТҮХ	ЭМБ-ууд
10	Эрүүл мэндийн байгууллагуудын ажилчдын урлагийн наадам зохион байгуулах	2-р улирал	НЭМТ	ЭТҮХ, ХШҮМХ
11	“Гепатитгүй–Монгол” төслийн хүрээнд элэгний хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, шинжилгээг ОУ-ын байгууллагатай хамтран зохион байгуулах	1-4-р улирал	НЭМТ	ЭМБ-ууд
12	Орон нутагаа дэвшилтэт технологиудыг нутагшуулах, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг ажлын байрны дагалдан сургалтад хамруулах /Хэвлий хөндийн болон урологийн мэс заслын дуран, үе солих, хавдрын хими эмчилгээ, хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр, чих хамаар хоолойн болон нүдний салстын мэс засал/	2-р улирал	НЭМТ	ЭТҮХ, ХШҮМХ, НЭМТ
13	Эрт илрүүлэг үзлэгийн чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Дэмжих төвийг ашиглалтад оруулах	3-р улирал	НЭМТ	ЭТҮХ, ХШҮМХ, НЭМТ
14	Хөдөөгийн алслагдсан цэгт амьдарч байгаа эрүүл мэндийн даатгалгүй ядуу эмзэг бүлгийнхнийг үзлэг шинжилгээнд хамруулах зорилгоор “Эрүүл Сүхбаатарчууд” төсөл хэрэгжүүлэх	2-4-р улирал	НЭМТ	ЭМБ-ууд
15	Засгийн газар, салбар болон орон нутгийн шагналаар шагнагдах эрүүл мэндийн байгууллагын ажилчдын шагналын материалыг авах, дээд шатны байгууллагад хүргүүлэх, шийдвэрлүүлэх	2, 3-р улирал	УТСХ	ЭМБ-ууд
16	Тоног, төхөөрөмжийн ашиглалт, хамгаалалтад хяналт үнэлгээ хийх	2-р улирал	УТСХ,	ХШҮМХ, НЭМТ ЭТҮХ
17	Эрүүл мэндийн байгууллагын ажилчдын спортын наадам зохион байгуулах	3-р улирал	ЭТҮХ	

1	2	3	4	5
	Мөнххаан сумын эрүүл мэндийн төв, Энхжин өрхийн ЭМТ-ийн шинэ барилгуудыг ашиглалтад оруулах	3-р улирал	УТСХ	Мөнххаан сумын ЭМТ, Энхжин өрхийн ЭМТ
19	Байгууллагын ажилчдыг эрүүл дадал хэвшилд сургах зорилгоор “Дугуйгаар аялангаа ярилцъя” сэдэвт спорт өдөрлөг зохион байгуулах	3-р улирал	НЭМТ	ХШҮМХ, ЭТҮХ
20	Хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийг хийх арга зүйд сургах “ анхан шатны ЭМТ-ийн эмч нарыг сургалтад хамруулах	3-р улирал	НЭМТ	УТСХ, ХШҮМХ, ЭТҮХ
21	“Эмчилгээний хоолыг сурталчлах “ бүсийн тогооч нарын ажил мэргэжлийн уралдаан , сургалт зохион байгуулах	3-р улирал	НЭМТ	УТСХ, ХШҮМХ, ЭТҮХ
22	Эрүүл мэндийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 80 жилийн ойн хүндэтгэлийн хурал, концеррт зохион байгуулах	2022 оны 9-р сар	ЭМГ, АНЭ	ЭМБ-ууд
23	Ахмадын өдрийг тохиолдуулан “ Ахмадын сургаал –Алт “ гурван үеийн хэлэлцүүлэг зохион байгуулах	10 сар	ЭМГ	ЭМБ-ууд